

МОНГОЛ ОРОН БА УЛС ТӨРИЙН ТОГТВОРГУЙ БАЙДЛЫН СОРИЛТ: ОРОСЫН УЛС ТӨРИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ДЭХ НИЙГМИЙН ХИЙРХЛИЙН АСУУДАЛД

*А.В.Михалёв**

XXI зууны эхэн үед Орос, Монголын харилцаа, хамтын ажиллагаа нь социализмын үеэс улиран үлдсэн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдэж байна. Монгол Улсад ОХУ-ын Ерөнхийлөгч нарын хийсэн айлчлалын үеэр ЗХУ-ын өрийг цайруулах тухай асуудал ерөнхийдээ шийдэгдэж, Оросын компаниуд Зөвлөлт-Монголын хамтарсан экспедицийн хайгуулын явцад нээж илрүүлсэн ашигт малтмалын нөөцийг олборлоход давуу эрх эдлэх ёстой байлаа. Дээрхи үйл явдлууд нь улс төр судлаачдад Орос орныг “Их Дорно” зүг рүү эргэж ирлээ гэж хэлэхэд хүргэсэн.¹ Гэвч шинэ нөхцөл байдалд үүссэн дэлхийн их гүрнүүдийн Төв Ази дахь “Томоохон тоглоом”² нь түүнийг эргэж ирэхэд хүндрэл учруулсан юм. Энэ сэргөлдөөний явцад Зөвлөлт Холбоот Улсын задралын дараа үүссэн зарим оронд (Америкаар-Төв Евразид) “өнгөт хувьсгал” удаа дараалан гарсан билээ. Энэхүү ер бусын явдлыг (феномен) системийн үзэгдлийнх нь хувьд улс төр судлаач мөн эдийн засагч нар аль аль нь цаашид судлана. Харин дээрхи үйл явдлууд нь 1990-ээд онуудад ЗХУ задарсны дараа нэгэнт бий болсон хүчний тэнцвэрийг алдагдуулсан нь өнөөдөр тодорхой болоод байна. Системтэй явагддаг үйл явцын логикийн дагуу ЗХУ-ын бүрэлдэхүүнд буюу түүний улс төрийн нөлөөллийн хүрээнд байсан орнуудад хувьсгал дараалан гарч төр засаг солигдохыг Орос улс хүлээж байв. Сүүлийн ангилалд нь (нөлөөллийн хүрээнд байсан гэдгийг хэлж байна орч.) багтах орон бол Монгол Улс юм. Өдгөө хүртэл тэрбээр (70 жилийн явцад Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын гол түнш байсан) МАХН нь давуу /монополь/ эрхийг эдэлдэг хамгийн тогтвортой улс хэмээн тооцогдож байв.³ Ийм байр суурь нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон шинжилгээ судалгааны ажилд ч тусгалаа олжээ. Иймээс 2006 онд хэрэг явдал өөрөөр илэрсний дараа Оросын зарим хэвлэлүүд ээлжит “өнгөт хувьсгал” гарсан тухай мэдээлсэн.⁴ Эдгээр баримт нь дээрхи үзэгдлийг нийгмийн хийрхлийн өнцгөөс харах боломжийг олгож байна.

Нийгмийн хийрхлийн ер бусын үзэгдэл нь Зөвлөлт Холбоот Улсын дараа үүссэн орон зайд улс төрийн хүрээний тодорхой бус байдлыг бий болгосон. Энэхүү үзэгдлийн судалгаа нь милленаризм болон ертөнц сөнөх тухай үзэл бодлыг судлах уламжлалаас эхтэй гэж хэлж болно. Дж.Маркус,⁵ К.Стюарт болон С.Хардингаас⁶ эхэлсэн академик судалгааны уламжлал нь XXI зууны эхэн үеийн Орос оронд болж буй улс төрийн хэлэлцүүлэг дэх “өнгөт хувьсгал”-ыг тусган авч буй бүтцийн мөн чанарыг илрүүлэх боломжийг олгож байна. Эдгээр шинэ төрлийн хувьсгал нь улс төрийн ер бусын үзэгдлийн хувьд Оросын тусгаар байдал, үндэсний эрх ашигт аюул учруулах шинэ заналхийлэл мөн хэмээн үзэгдэж байгаа юм. Анх сэтгэл

* А.В.Михалёв - ОХУ-ын Буриадын Улсын их сургууль, түүхийн ухааны дэд доктор

зүйн категорийг улс төрд хэрэглэх оролдлогыг К.Хэмфри⁷ өөрийн номондоо тусгажээ. Тэрбээр зохиолдоо дэлхийн ертөнцийн тухай хийрхэл солиорлын шинж чанартай ойлголт нь улс төрийн хэлэлцүүлэгт хэрхэн биеллээ олдог тухай бичсэн байдаг. Бидний судалгаанд энэ аргачлал аливаа нэгэн үйл явцын тухай буруу ташаа ойлголт нь хэрхэн яаж улс төрийн хүрээнд нөлөөлдөг гэдгийг судлан шинжлэх бололцоог олгож байгаа юм. Бид буруу ташаа ойлголт гэдгийг үндэс муутай айдас болгоомжлолоос үүдэн бий болсон үзлийг хэлж байна.

Хийрхэл нь бидний үзэж буйгаар байгалийн баялгийн төлөөх тэмцлээр улам хүнд хэцүү болж байна. Энд тэмдэглэхэд Тавантолгой, Оюу-Толгойн орд нь одоогоор ашиглагдаагүй бөгөөд тэдгээрт дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх, техник тоног төхөөрөмжийг бүрдүүлэх, ажлын хүчийг бий болгох шаардлагатай. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн ихэнхи нь энэ хүчин зүйлийг харгалзалгүйгээр тэдгээрийг ашиглалтанд орсон мэт мөн ашиглалтын төлөөх тэмцлийг төрийн эргэлтэй хүртэл холбож бичиж байна. Тэрбайтугай эдгээр ордуудыг эзэмшнээс хамааран тухайн бүс нутаг дахь улс төрийн хүчнүүдийн тэнцвэр орвонгоороо өөрчлөгдөнө гэсэн үзэл баримтлал бүрэлдээд байна.⁸ Оросын компаниуд Монголын байгалийн баялгийг олборлох эрхийн төлөө тэмцэлд ялагдсан нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байгаа болно. 2010 он гэхэд Оросын уул уурхайн томоохон үйлдвэрүүдээс Монголд зөвхөн ГОК “Эрдэнэт” болон “Алтан Дорнод” хоёр л үлдсэн. Сүүлч нь 2009 оны эдийн засгийн хямралд өртөн үйл ажиллагаагаа хумьчихаад байгаа юм. Уг явдлын өрнөлт нь Монголыг эдийн засгийн хувьд дахин хуваарилах үйл явц ойртож байгаа хийгээд үүнийг ээлжит “өнгөт хувьсгал” бататгаж өгнө гэсэн хандлага ч гарч байна. Дээр дурьдсан үйл явдлууд нь Орос оронд Монгол Улс дахь үйл явцын өрнөлтийн талаархи үндэслэлгүй таамаглалыг бий болгов. Энэ бүгдээс үндэслэн Монгол Улс дахь улс төрийн тогтворгүй байдлын илэрлийг Оросын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн тайлбарлаж буй хэв маягийг /модель/ судлахыг оролдов. Үүнд улс төрийн мэдэгдлийн мөн чанарыг авч үзэхийн сацуу мөн сүүлийн дөрвөн жилийн хэрэгжилтийнх нь механизмыг авч үзэх нь чухал юм.

Өнгөт хувьсгалыг судалгаа шинжилгээний загварын хувьд авч үзэх нь

ЗХУ задарсны дараа үүссэн орон зайд гарсан 2000-аад оны улс төрийн өөрчлөлтүүд ОХУ-ыг нэлээд сандаргав. Хуучин ЗХУ-ын бүгд найрамдах улсуудын ихэнхийнх нь улс төрийн дэглэмийн халаа “өнгөт хувьсгал”⁹ хэмээх нэр зүүжээ. Энэ үзэгдэл нь улс төрийн гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийг эргэж авч үзэх, өмчийг дахин хуваарилахтай холбоотой юм. Тогтолцооны өөрчлөлт нь өөрөө Евроазид улс төрийн тодорхой бус байдлыг бий болгосон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Өнгөт хувьсгалын мөчлөг хэзээ дууссаныг баттай тодорхойлж хэлэхэд бэрх. 2000-аад оны дундуур дараалан гарсан улс төрийн ээлжит донсолгоо болон аливаа нэг эсэргүүцлийн цуглаан түүн дээр хэлсэн үгийг бас нэг “өнгөт хувьсгал” шиг хүлээн авч, үргэлжлэлийг нь хүлээх нөхцөл

байдал үүсээд байлаа. 2000 оны хоёрдугаар хагаст улс төрийн хувьд Монгол, Киргизийн хувьд илүү хүндээр тусчээ.¹⁰ Монгол Улсын тухайд гудамжны эмх замбараагүй байдал бий болсон ба Киргизид үндэстэн хоорондын мөргөлдөөнөөр дууссан юм. 2008 онд Монгол Улс нийслэл хотдоо цэрэг оруулах, хамгаалалтын техник хэрэглэх гэх мэтийн онцгой шуурхай арга хэмжээ авсан явдлыг үндсэндээ бусад оронд үүссэн нөхцөл байдалтай адилтгаж авч үзжээ. Энэ бүхэн хилийн чанад дахь Гүрж, Молдов, Киргиз, Украин дахь үйл явдлын нөлөөгөөр ОХУ-д үүссэн хэт санаа зовоосон уур амьсгалд шууд нөлөөлөв. ЗХУ задарсны дараа үүссэн орон зайд Орос улс геополитикийн өөрийн байр сууриа үнэхээр алдлаа гэсэн сэтгэгдэл бий болжээ.

Үүний зэрэгцээ өөрийн нөлөөний төлөө хамрах хэмжээгээрээ “Томоохон тоглоом”-ыг Төв Азийн нутаг дэвсгэрт өргөн дэлгэр явуулав.¹¹ Дэлхийн улс төрийн байгууламжийн шинэ загварыг энэ тоглоомын гол жүжигчин АНУ дэвшүүллээ. Үүний тулд Төв Евроазийн бүс нутгийн загварыг энэ бүс нутагт хэрэгжүүлж байв. Тэр загвар нь үндсэндээ АНУ улс төрийн бодлогын хувьд давамгайлсан эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааны шинэ загвар гэдгээр ойлгогдож байна. Энэ тоглоомын тусгай раундад – Орос, Хятадтай хиллэдэг тухайн хилийн зурваст хамгийн тогтвортой байдаг Монголын төлөө, энэ нутагт улс төрийн бодлогоо тодорхойлох боломжийн төлөө тэмцэл¹² юм.

Монголын улс төр судлаач Төмөрийн Цэрэндорж 2006 онд бичихдээ, АНУ-ын хувьд Монгол нь стратегийн чухал орон бөгөөд Төв болон Зүүн Азийн хамгийн ойрын түнш мөн гэжээ. “Монголын аюулгүй байдлын тогтолцоо аяндаа бий болоогүй, шинэ геополитикийн нөхцөл байдлын хүрээнд АНУ-ын өөрийн эрх ашигт нийцүүлэн зассан стратегийн бодлогын хүрээнд бодитоор хэрэгжиж байна. Хэрэв дэлхий дахинд ялангуяа Төв болон Зүүн Азид шинээр солигдож буй геополитикийн бодит байдалд шинжилгээ судалгаа хийх аваас Төв болон Зүүн Азид өөрийнхөө стратегийн бодлогыг хэрэгжүүлж, өвөрмөц, үр ашигтай холбоотны бүс газрыг байгуулах гэсэн АНУ-ын санаархал улам бодитоор цухалзаж байна. Хэрэв Европод НАТО хэмээх хүчирхэг зэвсэг АНУ-ын хувьд хангалттай нөлөө бүхий хүчин, үр ашигтай зэвсэг хэвээрээ байгаа бол Ази-Номхон далайн бүс нутагт түүнтэй адил үр ашигтай бүтэц байгууламж алга байна. Үүнтэй холбогдуулахад, Хятадын санаархал /амбиц/ улам өсөн нэмэгдэж байгаа нөхцлийг харгалзан үзэж, Азид, Номхон далайн бүс нутагт Япон, Өмнөд Солонгос, Монгол, Австрали, Канад болон тухайн бүс нутгийн бусад зарим орны оролцоотойгоор НАТО маягийн холбоотны бүс газрыг байгуулах боломж, үйл ажиллагаа өрнөх явц гарахгүй гэдгийг өнөөдөр итгэлтэйгээр хэлж болохоор байна” хэмээн Цэрэндорж үзжээ. “Цэргийн холбоотны хувьд цэрэг армийн хамтын ажиллагаа болон харилцан ажиллах үйл хэрэг улам нягт хамтын ажиллагаанд шилжиж буй тодорхой шинж тэмдэг нь Монгол Улсын “Тавантолгой” дахь цэргийн сургалтын хээрийн буудлагын талбарт явуулж байгаа АНУ, Япон, Өмнөд Солонгос болон бусад орны цэргүүд

оролцдог олон улсын “Khan Quest” хээрийн сургууль юм.¹³ 1990-ээд оны үед Монгол Улс нь ЗХУ задарсны дараа Төв Азид үүссэн улсуудтай харьцуулвал харьцангуй тогтвортой бүс нутаг гэсэн сэтгэгдэл төрүүлж байлаа. Энэ бүх байдал нь Орос оронд Монголын талаархи зарим нэг хийрхлийг өдөөсөн хэрэг болж байв.

2006 оны хөдөлгөөн. Анх удаа 2006 оны 1 дүгээр сарын 12-нд олон нийт газрын тос, бензиний үнэ өссөн явдлыг нөхцөлдүүлэн гудамжинд гарч, үгээ хэлжээ. Монголд газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүнийг нийлүүлдэг улс нь Орос байсан учраас тэр цуглаан Оросыг эсэргүүцсэн шинжтэй байв. Үнийн өсөлт юуны өмнө жирийн иргэд болон автомашин тээвэрлэгчдэд хүндээр тусчээ. Улс төрийн хямрал нь нөхцөл байдлыг улам хурцатгаж, Засгийн газрын гишүүн, МАХН-ын 17 гишүүнээс 10 нь огцорч улмаар ерөнхий сайд, ардчилсан намын гишүүн Ц.Элбэгдоржид бүх хариуцлагыг үүрүүлэв. Тухайлбал: Пүрэв гарагийн өглөө Монголд ердөө ганц байдаг томоохон хот, улсын нийслэл Улаанбаатар хотын төв талбайд өнгөрсөн мягмар гарагт засгийн газраас МАХН-ын ихэнхи гишүүдээс бүрдсэн эсэргүүцлийн цуглаан эхлэв. Үнэн хэрэгтээ, албан ёсны мэдээгээр бол эдгээр хүмүүс улс төрийн хямралд оруулсан намынхаа эсрэг бус, харин нийслэл хотод нийтийн тээврийн үнэ өссөн явдлыг эсэргүүцэж байжээ. Олон нийт эхлээд Улаанбаатар хотын Тээврийг удирдах газар руу чиглэж байснаа дараа нь МАХН-ын төв байр руу очиж, хэдэн цагаар үймж хашгирч, энэ нам засгийн газрыг хэрхэн хямралд оруулсан тухай асууж мэдэх гэсэн боловч жагсагчидтай хэлэлцээр хийх, мэдээлэл өгөх хариуцлагатан, төлөөлөгчдийн хэнбугай ч байсангүй¹⁴ учир тухайн улс төрийн хямралыг Оросын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нэг төрлийн ээлжит “Улбар шар хувьсгал” хэмээн тодорхойлон шууд хүлээж авч, мэдээлж байсан. 2006 онд ойрхи хилийн чанадад гарч буй ямарваа нэг улс төрийн тогтворгүй байдлын аливаа илэрлийн талаар Оросын улс төрийн хэлэлцүүлэгт дээр дурьдсан нэр томъёог урьд өмнө хэрэглэж байгаагүй ихээр дурьдсан байна. Украин, Молдов, Киргиз, Гүржид урьд өмнө болж байсан үйл явдлыг дахин хэзээ давтагдах бол хэмээн Оросын улс төр байнгын хүлээлтийн байдалтай байсан гэж хэлж болох юм. Монголд хувьсгал гарснаар бүслэлтийг бий болгож, ОХУ-ын хилийн дагуу Оросын эсрэг хүрээллийг дуусгана гэж бодож байсан боловч талаар болжээ.

Монголын улс төрийн хямрал бол МАХН-ын хуучныг баримтлагчид либерал-ардчилсан хүчний улс төрчдийг засгийн газраас шахан гаргах зорилгоор хямралыг хиймлээр үүсгэн бий болгосон байна. Энэ тохиолдолд цөөнхийг төлөөлж ерөнхий сайд Ц.Элбэгдорж болон түүний “Эх орон-ардчилал” бүлгийнхний байдал нь тэдний эсрэг чиглэж байсан юм. Ардчилсан намын Гүйцэтгэх хороо засгийн газрыг огцруулах асуудалтай холбогдуулан хаалттай хуралдаан хийсэн байна. Эш татвал, Хуралдааны дараа Ардчилсан намын дарга Р.Гончигдорж сэтгүүлчдэд хандаж мэдэгдэл хийв. Тэрбээр, “Засгийн газрыг огцруулах тухай МАХН-ын Удирдах зөвлөлийн шийдвэр нь улс орны нийтлэг ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлын харилцаанд

алдаатай, маш хариуцлагагүй шийдвэр боллоо. МАХН-ын Удирдах зөвлөл өөрийнхөө гаргасан шийдвэрээс гарах үр дагаврыг өөрөө хариуцах ёстой. МАХН-ын Удирдах зөвлөлөөс өөрийнхөө шийдвэрийг хүчингүй болгож, Ерөнхий сайдад гардуулсан сайдаасаа татгалзсан өргөдөлөө буцаан авч, Ц.Элбэгдоржоор толгойлуулсан засгийн газрын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахыг Ардчилсан намын Гүйцэтгэх хороо шаардаж байна” гэж Р.Гончигдорж онцлов. МАХН-ын өргөдөлд дурьдсан шалтгаан нь засгийн газрыг огцруулах үндэслэл болохгүй гэдгийг Р.Гончигдорж тэмдэглээд “Ерөнхий сайдын асуудлыг шийдвэрлэх арга барил нь далайцтай, түргэн шуурхай, зоригтой, магадгүй зарим улс төрийн хүчин болон засгийн газрын гишүүдийн үргэлж болгоомжилдог, асуудлыг шийдвэрлэхдээ хойш тавьдаг арга барилтай зөрчилдөж байсан байж болно. Гүйцэтгэх хороо энэ бүхэн кабинетийн дотоодын зөрчил ч биш, засгийн газрыг огцруулах үндэслэл болохгүй гэж үзэж байна.” Тэрбээр мөн мэдэгдэхдээ, хэрэв одоогийн засгийн газар огцровол Ардчилсан нам, түүний гишүүд шинэ засгийн газрыг бүрдүүлэх үйл явцад оролцохгүй. Энэхүү шийдвэр Гүйцэтгэх хорооны төвшинд шийдэгдсэн гэдгийг Р.Гончигдорж тодорхойлов. Энэ асуудлыг мөн ням гарагт Үндэсний зөвлөлдөх хороогоор дахин авч хэлэлцэх болно гэж нэмж хэлэв.”¹⁵

2006 оны үйл явдалтай холбогдуулан ЗХУ задарсны дараах орон зайд үүссэн Төв Азийн орнуудыг Монголтой адилтгасан зүйлийн талаар улс төрийн мэдээлэл хийж, улмаар Оросын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч маш ихээр адилтгаж байсан юм. Тухайлбал: “Их хурлын болон засгийн газрын цөөнх болсон төлөөлөгчид Монголд хадгалдан үлдсэн нутгархаг үзэл-төрөл садны тогтолцоог ашиглан киргизийн загвараар засгийн газрыг унагаах эсэргүүцлийн ажиллагаа зохион байгуулж, өнөөгийн Засгийн газрын дампуурлыг арилгахын эсрэг бус, харин өөрийнхөө байр суурийг үлдээхийн тулд өөрсдийнхөө хамаатан садныг олноор нь гудамжинд гаргаж жагсааж байна. Киргизид сонгуульд ялагдсан депутатууд өөрийн “овгийнхнийг” гудамжинд гарган зөвшөөрөлгүй цуглаан хийж, “хувьсгал” гэгчийг яг ингэж л эхлүүлсэн биз дээ”¹⁶ хэмээн бичиж байлаа.

Дээр дурьдсан зүйлээс харахад, улс төрийн дээд давхрагад нутгархаг үзэл-төрөл садны харилцаа байгааг онцгойлон тодотгож Киргизтэй адилтгасан байна. Гэтэл Монголд иймэрхүү холбоо нь янз бүрийн бүлгүүдийн нөлөө, ашиг сонирхлын нээлттэй бодлогын хүрээнд явагддаг намын тогтолцоогоор илэрхийлэгдэнэ. Гудамжны мөргөлдөөнд намын идэвхтэнүүдийн хажуугаар хүн амын туйлширсан хэсгийн төлөөлөгчид оролцдог. Иймээс тухайн хувьсгалыг бүрдүүлэгч хүчин зүйл болох нутгархаг үзэл, хамаатан садны холбоо хөдөлгөөнийг явуулдаг, АНУ-ын оролцоотой адилтгаж авч үзэж болохгүйтэй адил юм. Интернетэд бичигдснээр, “Монголын улс төрийн дотоодын тэмцэл гадны ямар ч хүчний оролцоогүйгээр аяндаа гардаг. Улаанбаатар хотыг бараг 16 дахь бүгд найрамдах улсын нийслэл хэмээн үзэж байсан, энэ орныг ЗХУ задарсны дараа, ОХУ, БНХАУ, АНУ үнэндээ сонирхдоггүй байснаас түүний хүчний тэнцвэр зүгээр л хадгалагдан үлджээ. Магадгүй, америкчууд Монголд өөрийн цэргийн баазыг байгуулж, түүнийг

өөрийн бүс нутагт нөлөөний хүрээнд оруулж, БНХАУ, ОХУ-ын эргэн тойронд “аюулгүй байдлын бүс” хэмээн нэрлэгдэх бүс байгуулах хүсэлтэй байсныг 2005 онд Улаанбаатар хотод Жорж Бушийн хийсэн товч айлчлал нотолж байна. Гэхдээ АНУ энэ орныг улаан цайм “өөрийнхөө дор оруулахыг” хараахан хүсэхгүй, иймээс Украин, Киргизид болсон “өнгөт хувьсгал” шиг бэлтгэл ажилд нь зориулж төрийн бус олон зуун байгууллагыг байгуулаагүй. Иймд одоогийн эсэргүүцэл бол хувьсгал биш, зүгээр л нутгархсан тогтолцоог өөрийнхөө улс төрийн бодлогод ашигласан Монголын өнөөгийн нөхцөл байдлын гэрч юм. Албан тушаалыг ихэнхи нь өөрийнхөө баяжих хэрэгсэл гэж үздэг тэдгээр улс төрчдийн олонхи нь эмх замбараагүй байдлыг үүсгэж өрсөлдөгчийнхөө эсрэг нийслэл хотын төвд орилж хашгирч, эмх замбараагүй байдал үүсгэж, өрсөлдөгчийнхөө албан газрын байрыг эвдэж сүйтгэхэд бэлэн байна”¹⁷ гэжээ.

Монгол Улс бол засаг төр нь, эдийн засгийн нөөц нь нягт төвлөрөөгүй орон гэж Өрнөдийн судлаачид үнэн зөвөөр тэмдэглэдэг.¹⁸ Энэ хүчин зүйл бол улс төрийн тогтвортой байдалд нөлөөлж байгаа бөгөөд нэг ч улс төрч улс орныхоо гадаад улс төрийн бодлогын чиг хандлагыг үндсээр нь өөрчлөх боломжгүй юм. Энэ нь БНХАУ-аас өргөн хэрэгцээнийхээ барааг, ОХУ-аас газрын тос, цахилгаан эрчим хүчийг нийлүүлж байгаа бодит хүчин зүйлээр тайлбарлагдана. Улс төрийн бодлого дахь эрс өөрчлөлт нь улс орныг эдийн засгийн уналтын ирмэгт хүргэдэг.

2008 оны үйл явдал. 2008 онд Улаанбаатар хотод олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын давалгаа хүнгинэж, улмаар Орос оронд ээлжит “өнгөт хувьсгал”-ын тухай мэдээллийг ихэсгэв. Монголд гарч буй эмх замбараагүй байдлын шалтаг нь их хурлын сонгуулийн үр дүнг Ардчилсан намын тэргүүлэгчид хуурамч луйвар боллоо хэмээн мэдээлснээс болжээ.

2008 оны УИХ-ын сонгуулийн дүн

Нам	Санал %	Суудлын тоо
МАХН	51,3	39
МАН	32,8	25
Бусад нам болон бие даагч	13,1%	10

Хотод эсэргүүцлийн цуглаан, эмх замбараагүй байдал дараалан гарч эхлэв. Монгол Улсад 2008 оны 6 дугаар сарын 29-нд болсон сонгууль бүхэлдээ урьд өмнөх сонгуулиудыг бодвол илүү зохион байгуулалттай, элдэв янзын ноцтой зөрчилгүй болсон гэдэгтэй юуны өмнө хэвлэлийн төлөөлөгчид болон гадаадын ажиглагчид санал нэгтэй байв. Монгол Улсад суугаа АНУ-ын элчин сайдын яам сонгуулийг ихэд гярхай ажиглаж байв. Тэрбээр Улаанбаатар дахь сонгуулийн тойргуудаар явж, хэд хэдэн аймгаар 23 хүн очиж, АНУ-ын элчин сайд Марк С.Минтон өөрөө нийслэлийн 3 дүүргийн сонгуулийн тойрогт хүрэлцэн очиж, сонгуулийн хорооны төлөөлөгч, намын ажиглагч, сонгогдогчидтой уулзсан байна. Америкийн элчин сайд сонгууль бүхэлдээ бэлтгэл сайтай, үр дүнтэй болж өнгөрлөө

гэдгийг баталсан билээ. Гэвч олныг хамарсан эмх замбараагүй байдлыг арилгаж чадсангүй. Эш татвал: “Монгол Улсад 6 дугаар сарын 29-нд Их хурлын сонгууль болов. Санал хураалтын урьдчилсан дүнгээр Их хурлын 76 суудлын 45 мандатыг эрх баригч МАХН, сөрөг хүчний Ардчилсан нам зөвхөн 21 суудал авчээ. Маргааш өдөр нь Монголын нийслэлд сонгогчид сонгуулийн үр дүнд сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлэхээр гудамжинд гарч, эмх замбараагүй байдлыг бий болгов. Сөрөг хүчний “Иргэний хөдөлгөөн” намын /их хуралд орж чадаагүй/ хэдэн мянган хүн сонгуулийг будлиантуулсан хэмээн хардаж сэрдэн, эсрэг намын төв байрыг шатаажээ. Монгол Улсын ерөнхийлөгч Намбарын Энхбаяр тэр даруй улс орон даяар 4 хоногийн онцгой байдал зарлажээ. Цагдаагийнхан резинэн сум, нулимс асгаруулагч хий, усан буу хэрэглэсэн боловч сөрөг хүчнийхэн тарахгүй байлаа. Юутай ч гэсэн орон нутгийн цагаар 22 гэхэд хөл хорио /комендант/ цаг эхлэв. Шөнө дөл болтол эмх замбараагүй байдал үргэлжилж, дээрэм тонуул, банк дээрэмдсэн тухай, мэдээлэл урьдын адил Улаанбаатараас ирсээр байв. Тухайлбал: эсэргүүцэгчид театр, музей, үндэсний уран зургийн галерей байдаг нийслэлийн Соёлын төв өргөөг шатаалаа. Дээрэм тонуул хийж байсан олон түмэн хотын төвд байдаг уран зургийн галерейгаас телевизор, албан байгууллагын тоног төхөөрөмжийг хэрхэн авч байгааг харсан хүмүүс мэдээлж байв. Эмх замбараагүй байдалд оролцогчид автомашинууд шатааж, барилгын шил цонх хагалж байсан бөгөөд цагдаа нар бүхий л хүчээрээ мөргөлдөж байлаа. Босогчдыг МАХН-ын төв байр руу дөхөж ирэхэд, байр руу цагдаа нар руу шидүүлэх гэж зориуд тэдэнд чулуу, дотор нь будаг хийсэн хуванцар савнуудыг авчирч өгсөн гэдгийг төр, засгаас нотолжээ. Үүнээс гадна гар хийцийн дэлбэрэх бөмбөг хийсэн тухай яриа байв. Сүүлчийн мэдээгээр дор хаяж 4 хүн нас барж, 70 гаруй хүн хүндээр гэмтэж бэртсэн байна”.¹⁹

Дээрхи үйл явдлын цуурай Орос оронд асар хүчтэй сонсдож, “Нэгдсэн Орос” намын удирдлага Улаанбаатарт болсон хэт даварсан үйлдлийг шүүмжилж, Монголын удирдагчдыг дэмжсэн захидал бичжээ.²⁰ Монгол дахь эмх замбараагүй байдал нь Оюу-Толгойн орд газрын асуудлыг шийдвэрлэхтэй цаг хугацааны хувьд давхцсан байна. УИХ-д нэр дэвшигчдийн сонгуулийн компани ажил үндсэндээ өнгөт төмөрлөгийн ашигт малтмалын баялаг хуваарилахад давуу эрхийн эргэн тойронд явагдаж байв. (МАН-1 сая төгрөгийн хувьцаа, МАХН-иргэн бүрд 1 сая 500 мянган төгрөг өгөхөөр амалсан). Мөн түүнчлэн МАН нутагтаа шинэ орд газрыг боловсруулахдаа Өрнөдийн хөрөнгө оруулагчдыг татаж оруулна, ингэснээр хүн амын амьжиргааны төвшин дээшилнэ хэмээн ярьж байсан бол МАХН Оюу-Толгойн 51%-ийг улсын мэдэлд өгнө гэж байв.

Орос улс ч Монголын баялаг олборлох төслөөс хүртэхийг идэвхтэй санаархан уламжлал ёсоор МАХН-ыг дэмжиж байв. Монголд тэр үед Оросын “Ренова”, “БазЭл”, “Северсталь” зэрэг компаниуд байгалийн нөөц олборлох хүрээний томоохон тоглогчид болж байлаа. Ардчиллын сөрөг хүчин ялах тохиолдолд тухайн орд газрыг ашиглах боломжоо алдах аюул

тулгараад байв. ОХУ-ын ерөнхийлөгч Д.А.Медведев болон ерөнхий сайд В.В.Путин нарын Монгол Улсад хийсэн айлчлалын үед Монголын ашигт малтмалын орд газрыг олборлоход Оросын бизнесменүүдийн эрх ашгийг тусгасан тодорхой тодорхой хэлэлцээрт хүрсэн билээ. Ардчилагчид ялсан тохиолдолд бүс нутаг дахь ашигт малтмалын олборлолтонд шинэ хуваарилалт гарч болзошгүй байв. “Улаанбаатар хотод 7 дугаар сард болсон эмгэнэлт үйл явдлын ард томоохон бизнесийн ашиг сонирхол байна гэдэгт мэргэжилтнүүд эргэлзэхгүй байна. Монгол Улсын улс төрийн тэргүүлэх хоёр нам МАХН, МАН-ын харилцаанд эх орны байгалийн баялгийн хуваарилалтын хүрээнд ашиг сонирхлын маргаан бий. Монгол Улс ашигт малтмалын – зэс, уран (дэлхийн нөөцийн 1/4), алт, нүүрсний нөөцөөр дэлхийн эхний 10 орны тоонд багтаж байна. Энэ нутаг эдийн засгийн олборлох салбарт хөрөнгө оруулалт хийхэд бэлэн байгаа гадаадын хөрөнгө оруулагчдыг маш ихээр татаж байгаа юм.”²¹ гэж Оросын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үнэн байдлыг нотолж бичиж байв.

Энэ үеэр Монгол Улсын ерөнхий сайд С.Баяр мэдэгдэхдээ, “эмх замбараагүй байдлыг сайн төлөвлөж хийснээс харахад ард нь зохион байгуулах хүч байгаа нь гарцаагүй. Эдгээр эмх замбараагүй байдал нь ЗХУ задарсны дараахи улс орнуудад болж өнгөрсөн “өнгөт хувьсгал”-ыг олон талаар санагдуулж байна”²² гэж мэдэгдэв. Энэхүү болоогүй хувьсгалын нэрийн хувилбар маш олон байв. Тухайлбал: “ноолуурын хувьсгал”, “өнгөт төмөрлөгийн хувьсгал”, “Монгол гэрийн хувьсгал” гм. Энэ улсын өмч хөрөнгө, засаг төрийн төлөөх тэмцлийн эргэн тойронд өрнөсөн үйл явдалд ийм сүржин нэр хаяг зүүжээ.

2010 оны 4 дүгээр сар. 2010 оны хавар гарсан үйл явдал Монголын хөгжилд шинэ түлхэц боллоо. Улаанбаатар хотод эсэргүүцлийн хэд хэдэн үйл явдал болжээ. Жагсаал цуглаан, уриа тунхаг мөн л МАХН, МАН-ын төлөөллөөс бүрдсэн эвслийн засгийн газрын эсрэг чиглэж байв. Асуудлын гол зангилаа нь 2009 онд Монголд ажилгүйдэл, импортын бараа болон цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийг бий болгосон явдлаас үүдсэн эдийн засгийн хямрал байлаа. Үүнээс гадна 2009-2010 онд хахир хүйтэн өвөл болж, зудтай байснаар монголын малын тэжээл хомсдож, мал сүрэг олноороо үхжээ. Босогчдын ихэнхи нь малчид байж, засгийн газраасаа ахуй амьдралаа шийдвэрлэхэд нь тусламж үзүүлэхийг шаардан гудамжинд гарчээ. Тухайлбал: Дундговь аймгийн оршин суугч Х.Базарсад: “Өнөөдөр улс оронд ядуурал нүүрэлж байна, өвс тэжээл юу ч байхгүй яагаад гэвэл улс өөрийн үүргээ биелүүлэхгүй, хэтэрхий хариуцлагагүй байна.”²³ гэж мэдэгдэв.

2010 онд болсон иймэрхүү эсэргүүцлийн үйл ажиллагаа Монголын өөрийн нь улс төрийн хөгжил Төв Азийн орнуудын хөгжлийн чиглэл, онцлог шинжээс хол гэдгийг бас гэрчилж байгаа юм. Парламентаризм, намын тогтолцоо гэх зэрэг улс төрийн албан ёсны институтиудын хөгжил сонгуулийн явцад засгийн эрхийн төлөө илээр тэмцэл хийхэд ашиглах арга хэрэгсэл болдог байна. Олон намын тогтолцоотой нөхцөлд гарч буй олон нийтийн тэмцэл нь сонгогчдыг худалдаж авах сөрөг муу үзэгдэл болдог.

“Монголын нийслэл Улаанбаатар хотод хүн амын амьжиргааны төвшин буурсныг эсэргүүцсэн олон нийтийн жагсаал цуглаан болов. Хэрэв засгийн газар үндэсний түүхий эдийн нөөцийн ашиглалтын орлогоос тухайн орны оршин суугчдад тараахгүй тохиолдолд их хурлыг тараахыг үйл ажиллагаанд оролцсон ойролцоогоор 100 мянга гаруй хүн шаардаж байна гэж ИТАР-ТАСС мэдээлэв. Жагсаалыг санаачлагчид уул уурхайн аж үйлдвэрийн орлогыг хүн амын нэн ядуу давхрагад засгийн газрын тэтгэлэг юмуу эсвэл нийгмийн халамжийн тусгай сан байгуулах замаар хуваарилах тухай өөрсдийн үүргийг гүйцэтгэхээс тагталзсан, сонгогчдыг хуурсан хэмээн засгийн газарт эвсэл болж орсон МАХН болон МАН-ыг буруутгажээ. Бид засгийн газарт 72 цагийн бодох хугацаа өгч байна. Бидний шаардлагыг үл хэрэгссэн тохиолдолд эсэргүүцлийн дараагийн шатны үйл ажиллагаанд хүрнэ”²⁴ гэж жагсагчид мэдэгджээ хэмээн интернетийн сайтэд бичжээ.

Цуглаан хийх болсон үндсэн шалтаг нь нэр дэвшигчид сонгуулийн өмнө, тухайлбал уул уурхайн салбарын орлогоос Монголын иргэн бүрд 1000 ам.долл төлөх гэсэн амлалтаа биелүүлээгүй явдал байлаа. Үндсэн хуулийн 6 дугаар бүлгийн 1 дүгээр зүйлд зааснаар энэ мөнгийг авах эрхтэй гэж жагсагчид үзэж байв.²⁵ Дээр заасан хэсэгт Монголын байгалийн бүх баялаг ард түмний өмч хэмээн тунхагласан байна. Үүний сацуу сонгогчид саналаа өгсөн боловч мөнгө төлөгдөөгүй байна, сонгуулийн өмнөх амлалтаа биелүүл гэсэн уриа сонсдож байв. Үүнээс гадна их хурлын гишүүд сонгуулийн үеэс төлбөр хийхээс хагас жилээр хойшлогдсон байсан бөгөөд эдийн засгийн хямрал ард иргэдийг гудамжинд гаргахад хүргэсэн гэж үзэж байна.

2010 оны үйл явдал өлсгөлөн зарлаж, цуглагсдын тоо 10 хүртлээ цөөрч, эмнэлэгт хүргэгдснээр дуусчээ. Сүүлийн үеийн шаардлагаар нийгэм-эдийн засгийн шинжтэй шаардлагыг илүү түлхүү дэвшүүлэн тавьсан байна. Энэ үеэр Оросын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэ үйл явдалд тайлбар, дүгнэлт хийхээс цааргалж, тэр тухай бараг бичиж нийтлээгүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Үр дүн нь “улбар шар заналхийлэл”-ийг дэвэргэх үйл явц төгсгөл боллоо хэмээн үзэж болно.

Улс орны улс төрийн тогтворгүй байдлын төвшинг тодорхойлох гол зангилаа чухал хүчин зүйл нь тухайн нөхцөл байдалд засгийн эрхийн төлөө болон газрын баялгийн хуваарилалтын эрхийн төлөө тэмцэл юм. Тавантолгой болон Оюу-Толгойн эдийн засгийн асар их нөөцийн төлөө тэмцэл нь засгийн эрхийн төлөө тэмцлийн арга барилыг тодорхойлно. Эцсийн бүлэгт дээрхи болон бусад орд газрыг хэний гарт шилжүүлэхийг шийдвэрлэх эрхийн төлөөх тэмцэл юм. Улс төрийн тогтворгүй байдлын үзэгдлүүд нь гадаадын хөрөнгө оруулагчдад сануулга дохио өгөх ёстой байсан агаад 2010 оны 5 дугаар сард Тавантолгойн ордыг олборлох тухай санаа зорилгоо мэдэгдэж байсан нь энэ оронд “Монгол - 999” гэдэг Монголын корпорацийг байгуулах хөрсийг бэлтгэж өгчээ. Үндсэндээ бидний яриад байгаа энэ бүхнийг тодорхойлон шүүн тунгааваас, сүүлийн дөрвөн жилд Монголд гарсан эмх замбараагүй байдал нь “өнгөт хувьсгал”-тай ямар ч холбоогүй. “Улбар шар хүчин зүйл” монголын улс төрчдийн гараар Орос, Хятадын зүгээс анхаарлыг

өөрийнхөө оронд төвлөрүүлэх гэсэнд маш их хэрэг тус болсон байна. Тэрбайтугай Орос улс Монголд эд материалын тусламж үзүүлж, өр төлбөрийн хэсгийг данснаасаа хассан байна.

Монголын “өнгөт хувьсгал”-ын талаархи Орос орон дахь нийгмийн хийрхэл нь Монголын дотоод хэргийн тухай мэдээлэл тааруу байсны үр уршиг юм. Оросын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл Монгол Улсыг хуучин ЗХУ-ын бүгд найрамдах улсуудтай адилтган үзэж, энэ орон Евразийн шинэ тулгар бие даасан улсуудыг бодвол төр ёсны түүхийн урт удаан хөгжлийн замыг туулсан гэдгийг дандаа умартаж мэдээллээ цацдаг. Улс төрчид “өнгөт хувьсгал”-ын үзэгдэл ер бусын хэлбэрээр гардаг гэдгийг мартаж, задлан шинжилгээ хийхдээ үйл явдлын өрнөлд зөвхөн ганц “киргизийн схем”-ийн хувилбарыг хэрэглэж байна.²⁶ Харин Монголын улс төрийн тогтворгүй байдал өөрийн гэсэн мөн чанарыг агуулсан байдаг.

2000 оны эхэн гэхэд энэ орон парламентын нөхцөлд оршин тогтнох тодорхой хэмжээний туршлага хуримтлуулжээ. Аль аль намын хүчээр өөрийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлсэн томоохон олигархиудын хөрөнгө бүрэлдэн тогтжээ. Амьдралын доод төвшиний улмаас нийгмийн задрал бий болж, хэт даварсан этгээдүүдэд хөглөгдөн идэвхжиж байна. 2,8 сая хүн амтай энэ оронд зэс, алт, нүүрс, молибдений томоохон орд газрын төлөө тэмцэл нэг хүн амд ногдох бүтээгдэхүүний хуваарилалт тэнцвэртэй бус байгаад шүүмжлэл хүртэх ёстой. Энэ оронд дундаж цалин өдөрт 1 ам.долл гэдгийг сануулья. Үүнээс гадна 2004 оноос эхлэн Монгол Улс олон улсын “International Amnesty” байгууллагын бүртгэснээр авлигатай орны жагсаалтанд багтаж, 145 орноос 85-р байранд орж /10-аас/ 3 гэсэн үнэлгээ авсан “хээл хахууль, авлигыг хязгаарлаж дийлэхгүй” орнуудтай ойртож оржээ.²⁷

Өөр нэг чухал асуудал бол тухайн оронд төвлөрлийн төвшинг багасгах явдал юм. “Дэлхийн Банк”-ны шинжээчдийн судалгаагаар, Монгол Улс энэ шалгуурыг тэргүүлж байгаа юм байна. Энэ хэмжүүр нь ардчилсан орнуудын төвшинг тодорхойлох үндсэн хэмжүүрийн нэг ажээ. Төрийн байгууллагын засаг захиргааны хүний нөөцийн хэмжээ, эдийн засаг дахь төрийн оролцоо “жинхэнэ бодит монополь” байгаа эсэх гэдгээр тайлбарлагдана. Ийнхүү 2000-аад оны эхээр Монгол Улс нь улс төрийн хэт төвлөрлийн төвшингөөр Колумби, Никарагуа улсын дараа гуравдугаар байрт оржээ.²⁸ Дээрхи нь улс төрийн дотоодын тогтвортой байдалд үзүүлэх хүчин зүйл мөн.

Социализмын дараахи Монголын улс төрийн институтчилагдсан байдлын онцлог нь улс төрийн намуудын нөлөөлөл юм. Монголын энэ шинж чанар бол үндсэндээ улс төрийн институт нь овог-ураг төрлөөрөө буюу орон нутгийн зарчмаар зохион байгуулагддаг ургийн холбоотой ЗХУ задарсны дараахи орон зайд үүссэн Төв Азийн орнуудаас тэс өөр гэдгийг ялгаж өгч байгаа юм.²⁹ Иймэрхүү хэлбэрээр ардчилсан парламентын засаглалын тусламжтайгаар Монголын дээдсийн /элит/ бүлгийнхэн өөрийнхөө эрх ашгийг хэрэгжүүлдгийг харуулж байна. Нөгөө нэг тал нь

Монгол Улс нь хэмжээгүй эрхт засаглалаас зайлсхийж, олон намын тогтолцоог хадгалж байгаа нь дээрхи шалтгаантай хүчин зүйл юм. Монголын хил дээр тогтворгүй бус байдал үүсэх, Орос, Хятадаар зааглагдсан Төв Азийн орнуудаас алслагдсан, энэ нь Төв азийн исламын шашны фундаментализмын үндэс болсон хар тамхины замаас хол байгаа явдал мөн үүнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ бүхэн нь тухайн орны улс төрийн хүрээн дэх хүчний харьцангуй тэнцвэртэй байдлыг бий болгож, улмаар социал-демократ, либерализм, консерватизм гэсэн улс төрийн сонгодог хэлбэр төдий үзэл сурталд чиглэгдсэн улс төрийн институтиудын багцыг бий болгожээ. Түүгээр зогсохгүй энэ оронд эртний буддын шашныг сөргүүлэн тавьсан, улс төрийн либераль намууд руу чиглэсэн үйл ажиллагаатай АНУ, Өмнөд Солонгосын христийн шашны нэгдлүүд түгээмэл болжээ.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. С.Г.Лузянин. Восточная политика Владимира Путина. Возвращение России на “Большой Восток” (2004-2008 гг.). М., 2007.
2. The Colour Revolutions in the Former Soviet Republics: Successes and Failures. London and New York, 2010
3. www.strana.ru/stories/06/01/12/3665/270162.html.
4. http://www.pravostok.ru/ru/conference/ch_fareast/conf_3/?id=28.
5. Paranoia Within Reason: A Casebook on Conspiracy as Explanation. Chicago, 1999.
6. Stewart K. Harding S. Bad Endings: American Apocalypse //Annual Review of Antropology. 1999. Vol. 28.
7. К.Хамфри Постсоветские трансформации в азиатской части России. М., 2010.
8. Деятельность США в Монголии может спровоцировать распад России по “байкальскому меридиану” //www.regnum.ru/news/1258426.
9. The Colour Revolutions in the Former Soviet Republics: Successes and Failures. London and New York, 2010.
10. Engvall J. Kyrgyztan’s Revolt: Prospect for Stability in a Failing State //CACI Analyst. 04/14/2010, а также Бойкова Е.В. События в Монголии: продолжение следует... //www.centrasia.ru/newsA.php?st=1215635340.
11. А.А.Казанцев “Большая игра” с неизвестными правилами: мировая политика и Центральная Азия. М., 2008.
12. Hyer E. “The Great Game”. Mongolia between Russia and China // The Mongolian journal of international Affairs. 1997. №4.Р.43-48.
13. Т.Цэрэндорж Монгольский фактор. Россия – пассивна, Китай – активен, США – суперактивны //www.centrasia.ru/news.php4?st=1149404280.
14. В столице Монголии проходят акции протеста //www.strana.ru/stories/06/01/12/3665/270162.html.

15. В столице Монголии проходят акции протеста // www.strana.ru/stories/06/01/12/3665/270162.html.
16. столице Монголии проходят акции протеста // www.strana.ru/stories/06/01/12/3665/270162.html.
17. В столице Монголии проходят акции протеста // www.strana.ru/stories/06/01/12/3665/270162.html.
18. Mearns R. Decentralisation, Rural Livelihoods and Pasture-Land Management in Post-Socialist Mongolia //European Journal of Development Research, Vol.16, No.1, Spring 2004, pp.133–152.
19. Разгневанные монгольские избиратели сожгли музеи, банки и штаб противника// www.newizv.ru/news/2008-07-03/93157/
20. www.owasia.ru.
21. Е.Бойкова. События в Монголии // www.warandpeace.ru/ru/analysis/view/25020/.
22. В Монголии зреет “Оранжевая революция” // www.old.pnp.ru/chapters/world/world_6816.html.
23. ww.tvcom-tv.ru/news/16/5170.php?phrase_id=172272.
24. Монголы потребовали от правительства поделиться доходами с бедняками// www.rosbalt.ru/2010/04/05/725827.html.
25. Цит. По переводу на русс.яз. Кручкин Ю. Монголия. Энциклопедический справочник. М.2002. С. 201-304.
26. The Colour Revolutions in the Former Soviet Republics: Successes and Failures. London and New York, 2010.
27. А.Б.Парканский. Американо-Монгольские экономические отношения //Проблемы Дальнего Востока. 2010. №1. С.61-69.
28. Mearns R. Decentralisation, Rural Livelihoods and Pasture-Land Management in Post-Socialist Mongolia // European Journal of Development Research, Vol.16, No.1, Spring 2004, pp.133–152
- 29 . Ш.Кадыров. Элитные кланы. Штрихи к портретам. М.2010.

*Орос хэлнээс орчуулсан: Ч.Батцэцэг (ОУСХ-ийн эрдэм
шинжилгээний ахлах ажилтан,
доктор, (Ph.D), дэд профессор)*